



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 43 (180)

## Монгол Улсын Хууль:

- *Нийгтийн хангамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай*

## Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *Хөдөлмөрийн хөлсний доод хэтжээг шинэчлэн тогтоож төрдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот  
2000 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны арваннэгдүгээр сарын 21 №43 (180)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

471. Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2000-11-3-ны хууль) 769
472. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай (2000-11-3-ны хууль) 770

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

473. Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай Дугаар 153 771
474. Жагсаалтад нэмэлт оруулах тухай Дугаар 154 771
475. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх тухай Дугаар 155 771
476. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 156 772
477. Хүүхдийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай Дугаар 157 772

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

### Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

**1 дүгээр зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"15.1. Төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ 1 нас /ихэр бол 3 нас/ хүртэл асарч байгаа эх /эцэг, асран хамгаалагч/ амаржсаны тэтгэмжээ авсны дараа хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй."

2/ 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх

заалт:

"29.3.1. хүүхэд эсэн мэнд өсөж байгаа тухай ерхийн эмч, баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;"

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Л.ЭНЭБИШ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 11 дүгээр  
сарын 3-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ИМПОРТ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭЛТИЙГ ХОРИГЛОХ, ЭКСПОРТЛОХ ТУХАЙ

#### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрийг аюултай хог хаягдлаас хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль тогтоомж

2.1. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль тогтоомж нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль,<sup>1</sup> Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль<sup>2</sup> энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл. Аюултай хог хаягдлын үндэсний тодорхойлолт

3.1. Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенцид тодорхойлсны дагуу хүн, амьтны эрүүл мэнд, үр удамд сөргөөр нөлөөлж, тэдгээрт өвчин эмгэг үүсгэдэг буюу байгаль орчны тэнцлийг алдагдуулдаг шинж чанар бүхий хог хаягдлыг аюултай гэж үзнэ.

3.2. Тэсрэмтий, шатамхай шингэн буюу хатуу, өөрөө шатдаг, цацраг идэвхт, хөрс, агаар, устай харилцан үйлчилснээс хортой, эсхүл галын аюултай хий ялгаруулдаг, исэлдүүлэгч, идэмхий, органик хэт ислийн хаягдал нь аюултай хог хаягдалд хамаарна.

3.3. Энэ хуулийн 3.2.-т заасан шинж чанар бүхий аюултай хог хаягдлын нарийвчилсан тодорхойлолтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн албадтай хамтран тогтоож болно.

#### 4 дүгээр зүйл. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох

4.1. Аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.

4.2. Аюултай хог хаягдлыг Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэхийг хориглоно.

#### 5 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг экспортлох зөвшөөрөл

5.1. Иргэн /Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хамаарна/, хуулийн этгээд аюултай хог хаягдлыг экспортлож болно.

5.2. Аюултай хог хаягдлыг экспортлох зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь нөхцөлд олгоно:

5.2.1. аюултай хог хаягдлыг боловсруулан ашиглах техник, тусгай тоног төхөөрөмж байхгүй;

5.2.2. аюултай хог хаягдлын импорт тухайн улсад хүлээн зөвшөөрөгдсөн.

5.3. Аюултай хог хаягдлыг экспортлох этгээд нь зөвшөөрөл авах тухай бичгээр гаргасан өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

5.3.1. аюултай хог хаягдлыг импортлогч этгээдтэй байгуулсан гэрээ, импортлогч этгээдийн бичгээр гаргасан хүсэлт;

5.3.2. аюултай хог хаягдал импортлогч этгээдэд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөл.

#### 6 дугаар зүйл. Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах журам

6.1. Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах журмыг Засгийн газар тогтооно.

#### 7 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

<sup>1</sup> Байгаль орчныг хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл"-ийн 1995 оны 5,6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл"-ийн 1995 оны 5,6 дугаарт нийтлэгдсэн.



7.1. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол энэ хуулийн 4.1; 4.2; 5.2; 5.3-ыг зөрчсөн гэм буруутай иргэнийг 35000-50000, албан тушаалтныг 30000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр тус тус торгох шийтгэл ногдуулна.

7.2. Энэ хуулийн 7.1.-д заасан захиргааны зөрчлийг эрх бүхий албан тушаалтан дараахь харьяаллаар хянан шийдвэрлэнэ:

7.2.1. шүүгч энэ хуулийн 4.1;4.2.-т заасан зөрчил;

7.2.2. эрх бүхий улсын байцаагч энэ хуулийн 5.2;5.3.-т заасан зөрчил.

7.3. Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

### 8 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх

8.1. Аюултай хог хаягдлыг цуглуулах, савлах, түр байршуулах, тээвэрлэх, аюулгүй болгох, хадгалах журам зөрчиж хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас бусдын эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд учирсан хохирлыг гэм буруутай этгээд хариуцна.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Л.ЭНЭБИШ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 10 дугаар  
сарын 4-ний өдөр**

**Дугаар 153**

**Улаанбаатар  
хот**

**Улсын ерөнхий байцаагчийн  
эрх олгох тухай**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга Жигмэдцэдэнгийн Хүрэлсүхэд Стандарт, чанар, хэмжил зүйн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан

"Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай" Засгийн газрын 2000 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 5 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ  
САЙД**

**Ч.ГАНЗОРИГ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 10 дугаар  
сарын 4-ний өдөр**

**Дугаар 154**

**Улаанбаатар  
хот**

**Жагсаалтад нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зөвшөөрөл олгох журам"-ын хавсралтад дор дурдсан заалтыг нэмсүгэй:

"38. Загасны аж ахуй эрхлэх Хүнс, хөдөө аж ахуйн яам"

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД**

**Д.НАСАНЖАРГАЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 10 дугаар  
сарын 4-ний өдөр**

**Дугаар 155**

**Улаанбаатар  
хот**

**Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг  
шинэчлэн тогтоож мөрдүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Монгол Улсын 2000 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2000 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн хууль, "Хөдөлмөрийн хөлсний доод

хэмжээний тухай" хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төр, аж ахуйн нэгж, байгууллагын



ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын цагийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд 2000 оны 10 дугаар сарын 1-нээс 106 төгрөг 51 мөнгөөр, 2001 оны 10 дугаар сарын 1-нээс 146 төгрөг 45 мөнгөөр тус тус шинэчлэн тогтоож мөрдүүлсүгэй.

2. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өөрчлөлтийг дагаж нэмэгдэх зарим тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилтэд шаардагдах нэмэгдэл хөрөнгийг улсын төсвөөс гаргаж, хугацаанд нь олгох арга хэмжээг авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

Ш.Батбаяр нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 108 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Ш.БАТБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 10 дугаар  
сарын 4-ний өдөр**

**Дугаар 156**

**Улаанбаатар  
хот**

**Тогтоол хүчингүй болсонд  
тооцох тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ  
нь:

"Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоож мөрдүүлэх тухай" Засгийн газрын 2000 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 155 дугаар тогтоол гарсантай холбогдуулан "Зарим тэтгэмж, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн

газрын 2000 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 147 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.ЭНХБАЯР**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Ш.БАТБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2000 оны 10 дугаар  
сарын 6-ны өдөр**

**Дугаар 157**

**Улаанбаатар  
хот**

**Хүүхдийн хөгжлийг дэмжих зарим  
арга хэмжээний тухай**

Боловсролын тухай, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн холбогдох заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, "Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, хүүхдийн төлөө үйл ажиллагаа явуулах үндэсний чадавхийг нэмэгдүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог улам боловсронгуй болгох зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхдийн төлөө Үндэсний байгууллагын дүрмийг 1 дүгээр хавсралт ёсоор, Хүүхдийн хөгжлийг дэмжих талаар ойрын жилүүдэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан асуудлыг шуурхай

зохион байгуулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт, тэдгээрт шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Хөдөлмөр, хүмүүжил, сургалтын төвийн байрны уурын зуухыг шинээр барих, хөдөлмөр сургалт явуулахад шаардагдах тоног төхөөрөмж авахад зориулан 40,0 /дөчин/ сая төгрөгийг 2000 оны IY улиралд багтаан улсын төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. Хүүхдийн асуудлаар Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын иргэн, байгууллагуудад зөвшөөрөл өгөхдөө Хүүхдийн төлөө Үндэсний



хороотой зөвшилцдөг журамтай болох асуудлыг судлан шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

5. Энэхүү тогтоол болон хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг Засгийн газарт жил бүрийн 12 дугаар сард багтаан танилцуулж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт

үүрэг болгосугай.

<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД</b>	<b>Н.ЭНХБАЯР Ш.БАТБАЯР А.ЦАНЖИД Ч.УЛААН</b>
---	---

*Засгийн газрын 2000 оны 157 дугаар —  
тогтоолын 1 дүгээр хавсралт*

## ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх төв байгууллага нь Хүүхдийн төлөө Үндэсний хороо /цаашид Үндэсний хороо гэх/ байна.

2. Үндэсний хорооны зорилго нь хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг хөгжүүлэх, тэдэнд нийгмийн халамж, үйлчилгээ үзүүлэх, улмаар хүүхдийн байдлыг сайжруулах үйл ажиллагааг төрийн удирдлага зохицуулалт, хяналтаар хангахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

3. Үндэсний хороо нь Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенци, Үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.

4. Үндэсний хороо нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

5. Үндэсний хороо нь нэрэмжит шагналтай байж болно.

### Хоёр.Хүүхдийн төлөө үндэсний хорооны чиг үүрэг

6. Хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийн үндсийг боловсруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, энэ чиглэлээр салбар хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад дэмжлэг үзүүлнэ.

7. Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн байдалд үнэлгээ дүгнэлт гарган хүүхдийн эрхийг зөрчсөн үйл ажиллагааг зогсоох буюу гаргасан шийдвэрийг өөрчлөх, цуцлах саналыг холбогдох эрх бүхий байгууллагад гарган шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

8. Хүүхдийн эрх, хөгжил, нийгмийн

хамгааллын чиглэлээр үндэсний хэмжээнд нэгдсэн үйл ажиллагаа явуулахад бүх талын туслалцаа үзүүлнэ.

9. Хүүхдийн эрхийг хамгаалах зорилго бүхий байгууллагад тухайн асуудлаар арга зүйн туслалцаа үзүүлнэ.

10. Хүүхдийн эрхийг хамгаалах үйл ажиллагаанд байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэдийг татан оролцуулж, тэдгээрийн санал, санаачилгыг хөхиүлэн дэмжинэ.

11. Хүүхдийн асуудал эрхэлсэн орон нутгийн ажилтнуудад зориулж семинар, сургалт зохион байгуулан, тэдгээрийг мэргэшүүлэх ажлыг эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулна.

12. Хүүхдийн эрхийг хамгаалах талаар олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллана.

13. Хүүхдийн эрх, хөгжил, хамгаалал, аж байдлын талаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, түгээх, солилцох, судалгаа, сурталчилгаа явуулах болон хүүхдийн холбогдолтой асуудлаар мэдээллийн сан бүрдүүлнэ.

14. Хүүхдийн эрх ашигтай холбоотой санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх буюу холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

### Гурав.Үндэсний хорооны удирдлага, зохион байгуулалт

15. Үндэсний хороо нь хүн амын бодлогын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.

16. Үндэсний хорооны бүтэц, орон тоог батлах, даргыг томилж, чөлөөлөх асуудлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд



шийдвэрлэнэ.

17. Үндэсний хорооны дарга эрх хэмжээнийхээ асуудлаар Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэр гаргаж, биелэлтийг хангуулна.

18. Үндэсний хороо нь аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн төлөө төв, сум, хорооны хүүхдийн асуудал эрхэлсэн нийгмийн ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

19. Үндэсний хороо нь Хүүхдийн төлөө

Үндэсний зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

### Дөрөв. Үндэсний хорооны санхүүжилт

20. Үндэсний хорооны үйл ажиллагаа нь дор дурдсан эх үүсвэрээс санхүүжинэ:

а/улсын төсөв;

б/хөтөлбөр, төслийн санхүүжилт, хандив, тусламж;

в/бусад орлого.

*Засгийн газрын 2000 оны 157 дугаар тогтоолын 2 дугаар хэвсрэлт*

## ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

\ 2000-2004 он \

№	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хариуцах байгууллага
<b>Нэг. Хүүхдийн сурч хөгжих таатай орчинг тэгш бүрдүүлэх талаар:</b>			
1.1	2001-2010 онд Хүүхдийг хөгжүүлэх үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газар болон НҮБ-ын Хүүхдийн сангийн 2002-2007 онд хамтран ажиллах хөтөлбөрийг боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх	2001 оноос	ГХЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.2	Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны барилгыг ээлж дараатай засварлах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	2001-2004 онд	СЭЗЯ, БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.3	Орон нутгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний хангамжийг сайжруулах	2000-2001 онд	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.4	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг дүрэмт хувцсаар хангах ажлыг тодорхой үе шаттай зохион байгуулж, нэн ядуу өрхийн нэг хүүхдийг батлагдсан дүрэмт хувцсаар хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган хэрэгжүүлэх	2000-2001 онд	СЭЗЯ, БСШУЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.5	Ерөнхий боловсролын сургуульд хүүхдийг бүрэн хамруулах зорилгоор бүх шатны Засаг дарга, сургуулийн захиргаа хамтран жил бүр төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2000 оноос	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.6	Аймаг, нийслэлийн "Гэгээрэл" төвийг бэхжүүлэх, сургуулиас завсардсан хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа, хөдөлмөрийн дадлага олгоход чиглэсэн үйл ажиллагааг тогтмолжуулах	2000 оноос	БСШУЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга



1.7	Хүүхдийн зориулалттай барилга, байгууламжийн ашиглалтыг сайжруулах, хүүхдийн чөлөөт цагийг зөв өнгөрүүлэхэд үйл ажиллагааг нь чиглүүлэх, бизнесийн болон төрийн бус байгууллагуудын зүгээс энэ чиглэлээр ажил, үйлчилгээг явуулахыг дэмжих, хамтран ажиллах арга хэмжээг хэрэгжүүлэх	2000 оноос	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.8	Нийслэлд хүүхдийн номын ордонг сэргээн байгуулах, орон нутгийн хүүхдийн номын сан, уншлагын танхимыг арга зүйн удирдлагаар хангах	2003 онд	БСШУЯ, Нийслэлийн Засаг дарга
1.9	Хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлэх, гоц авьяастныг дэмжих Үндэсний хөтөлбөр боловсруулж, урлаг, соёл, спортын төв байгууллагуудыг түшиглэн хүүхдийн авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагаа явуулах	2001 оноос	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.10	Ерөнхий боловсролын сургуулиудад нийгмийн ажилтныг сонгон шалгаруулж, чиг үүргийнх нь дагуу ажиллуулах, тэдний дунд зохиох мэдээлэл, сургалт, сурталчилгааг идэвхжүүлэх, үйл ажиллагааны үр дүнгээр нь урамшуулах, хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2000-2004 онд	БСШУЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.11	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд ажил, мэргэжлийн баримжаа олгох сургалт, дадлагын чанарыг сайжруулах, өргөтгөх	2000-2004 онд	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.12	Сурагчдын дунд хичээлээс гадуур зохиох үндэсний соёл, ардын урлаг болон спортын дугуйланг ажиллуулах, тэдгээртэй ажиллах авьяастан, багш, дасгалжуулагч нарт зохих урамшил олгох журам тогтоон мөрдүүлэх	2000-2004 онд	СЗЭЯ, БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
1.13	Хүүхдэд сэтгэл санаа, эд материалын дарамт, шахалт үзүүлэх, бэлэг, хандив, тусламжийн хэлбэрээр хээл хахууль авах, ёс суртахууны доголдол гаргах зэрэг дутагдал, доголдлыг арилгах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх	2000 оноос	ХЗДХЯ, БСШУЯ
<b>Хоёр. Нийгмийн халамж анхаарал шаардсан хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэх талаар:</b>			
2.1	Хүүхдийг хүнд нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр гэр бүл, эцэг эхчүүдэд нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх "Гэр бүл төвтэй нийгмийн хөгжил" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх	2001 оноос	НХХЯ, ХТҮТ
2.2	Хараа хяналтгүй хүүхдийн иргэний болон засаг захиргааны харьяалал, тэдгээрийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоон, нийгмийн халамж үзүүлэх ажлыг тасралтгүй	2000 оноос	ХЗДХЯ, ХТҮТ, аймаг, нийслэлийн Засаг дарга





	захиргааны харьяалал, тэдгээрийн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоон, нийгмийн халамж үзүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулах		Засаг дарга
2.3	Хорихоос өөр төрлийн ялтай, эрх нь зөрчигдсөн болон хүчирхийлэлд өртсөн хүүхдийг орон нутгийн төрийн захиргааны байгууллагын бүртгэл хяналтад авч, тэдэнд боловсрол, мэргэжлийн чиг баримжаа олгох, ажлын байраар хангахад чиглэсэн арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотойгоор зохион байгуулах	2000 оноос	ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
2.4	Эцэг эхийн хараа хяналтаас гарч, олон жил тэнэмэл амьдралд дассан, гэмт хэрэг зөрчилд удаа дараа холбогдсон буюу бусад хүүхдэд сөрөг нөлөө үзүүлж байгаа хүүхдийг тусгайлан хүмүүжүүлэх арга хэмжээ авах эрх зүйн орчинг бүрдүүлэх	2000 оноос	ХЗДХЯ, БСШУЯ, НХХЯ
2.5	Гэр орноосоо дайжсан хүүхдүүдийг халамж, үйлчилгээний төвийн хяналтад авч хамгаалах, халамжлахад зориулан зарцуулсан зардал, хөрөнгийг тухайн аймаг, нийслэлийн төсвөөс гаргуулж байх эрх зүйн зохицуулалт бий болгох	2001 оноос	СЭЗЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
2.6	Гэр бүлдээ хэвийн амьдрах боломж нь хязгаарлагдсан хүүхдийг байрлуулах Халамжийн төвийн ажиллах журмыг боловсруулан мөрдүүлэх	2000 оноос	НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга
2.7	Хүүхдийн талаархи төрийн бодлого болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу хүүхдийг хөгжүүлэх, хамгаалах тодорхой ажлыг хөтөлбөр, төслийн хэлбэрээр зохион байгуулахад туслалцаа үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хөхиүлэн дэмжиж урамшил, хөнгөлөлт үзүүлж байх	2000-2004 онд	Аймаг, нийслэлийн Засаг дарга
2.8	"Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглох болон нэн даруй устгах тухай" Олон улсын хүүхдийн 182 дугаар конвенци, 190 дүгээр зөвлөмжид нэгдэх, Хүүхэд үрчлэлийн асуудлаар хамтран ажиллах тухай Гаагийн Конвенцийг батламжлах асуудлуудыг судалж шийдвэрлүүлэх	2001 оноос	ХЗДХЯ, ГХЯ, НХХЯ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 329612  
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487